



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дашинчилэн сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн
нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2025/013/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Булган аймаг
2025 он

Дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол
Утас: 7034-2580 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Анхбаяр

Утас: 7034-2580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
Асуудлыг онцолсон хэсэг.....	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал.....	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.4.1 Мөнгөн хөрөнгө	12
3.5.2 Авлага	12
3.5.3 Урьдчилгаа.....	13
3.5.4 Бараа материал	13
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө	13
3.5.6 Үндсэн хөрөнгө	13
3.5.7 Өр төлбөр.....	14
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	16
4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.7.1 Завсрын аудитын талаар.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580

Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.03.24 № 389

танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН ДАШИНЧИЛЭН
СУМЫН ЗАСАГ ДАРГА С.МЭНД-АМАР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Булган аймгийн Дашинчилэн сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дашинчилэн сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хуулиар олгогдсон бүрэн эрхийн хэтрүүлэн шийдвэр гаргаснаас төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй, үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан зөрчлүүд илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Нийт хөрөнгө өмнөх оноос 1,377.0 сая төгрөгөөр өссөн нь Хоршоо хөгжүүлэх сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгосон зээл нэмэгдсэн, ЗДТГ-ын малын нас дэвшилтийн орлого, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2024 оны ХХ/03 дугаар хуралдаанаар 37 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан зэрэг

• 632502736

нөлөөлсөн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөг)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	648,958.30	1,057,486.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	279,095.50	560,767.2
33	АВЛАГА	204,677.80	173,128.1
35	БАРАА МАТЕРИАЛ	165,185.00	323,591.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,229,125.30	2,197,867.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,229,125.30	2,197,867.7
39200	Биет хөрөнгө	1,219,530.80	2,189,048.2
39300	Биет бус хөрөнгө	9,594.50	8,819.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,878,083.60	3,255,354.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,878,083.60	3,255,354.1
51	Засгийн газрын хувь оролцоо	1,878,083.60	3,255,354.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	375,510.20	371,037.0
51200	Хуримтлагдсан үр дүн	1,188,415.60	2,565,686.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	314,157.70	314,157.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,878,083.60	3,255,354.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөг)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,815,267.10	5,965,485.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	376,308.00	651,222.1
110	Орлогын албан татвар	247,426.10	491,950.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	247,426.10	491,950.6
113	Хөрөнгийн албан татвар	90,015.80	85,455.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	38,866.10	73,815.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	392,208.20	1,629,143.5
120	Нийтлэг татварын бус орлого	389,220.80	1,620,143.5
121	Хөрөнгийн орлого	2,987.40	9,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,046,750.90	3,685,119.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,499,306.70	4,581,195.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,499,306.70	4,581,195.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	919,028.60	2,175,894.7

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	434,844.60	679,197.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,659.40	91,348.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,611.90	485,437.5
2104	Хангамж, бараа материалын зардал	41,241.80	52,983.7
2105	Нормативт зардал	1,614.00	669.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,889.00	84,618.6
2107	Томилолт, зочны зардал	7,647.50	9,752.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,178.70	28,903.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	232,341.70	742,984.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,580,278.10	2,405,300.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	315,960.40	1,384,289.8
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	11,645.00	1,900.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	90,355.40	8,920.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	237,250.00	1,377,269.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөг)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,649,319.60	1,649,319.60
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(8,486.00)	(8,486.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,640,833.60	1,640,833.60
9	Тайлант үеийн үр дүн	237,250.00	237,250.00
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,878,083.60	1,878,083.60
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,878,084.3	1,878,084.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,878,084.3	1,878,084.3
19	Тайлант үеийн үр дүн	1,377,269.8	1,377,269.8
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,255,354.1	3,255,354.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөг)

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,874,488.50	4,547,616.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	376,308.00	651,222.1
110	Орлогын албан татвар	247,426.10	491,950.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	247,426.10	491,950.6
113	Хөрөнгийн албан татвар	90,015.80	85,455.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	38,866.10	73,815.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,129.20	34,397.8
1181	Газрын төлбөр	32,686.90	36,127.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	50.00	3,290.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	127,857.50	207,162.0

120	Нийтлэг татварын бус орлого	124,870.10	198,162.0
121	Хөрөнгийн орлого	2,987.40	9,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,370,323.00	3,689,231.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,360,680.80	3,431,685.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,360,680.80	3,431,685.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,094,593.50	1,757,892.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437,948.90	684,325.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,917.40	86,227.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,404.60	485,437.5
2104	Хангамж, бараа материалын зардал	33,579.20	49,568.0
2105	Нормативт зардал	900.00	900.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,032.00	88,848.7
2107	Томилолт, зочны зардал	7,386.00	9,752.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,008.70	29,887.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	475,416.60	322,945.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,266,087.30	1,673,792.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	513,807.70	1,115,930.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	331,268.00	763,180.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	331,268.00	763,180.2
2200	Дотоод эх үүсвэрээр	331,268.00	763,180.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(331,268.00)	(763,180.2)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(182,811.10)	(71,079.0)
14	Бусад эх үүсвэр	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	182,811.10	71,079.0
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	-	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(271.50)	281,671.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	279,366.90	279,095.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	279,095.50	560,767.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөг)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,918,009,200.00	2,334,758,424.86	583,250,775.14	0.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,667,183,300.00	1,533,091,129.86	134,092,170.14	0.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,645,859,900.00	1,511,767,785.70	134,092,114.30	0.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	712,526,900.00	684,325,348.21	28,201,551.79	0.96
210101	Үндсэн цалин	393,524,700.00	393,841,646.84	(316,946.84)	1.00
210102	Нэмэгдэл	274,887,200.00	241,930,791.37	32,956,408.63	0.88

210104	Урамшуулал	44,115,000.00	48,252,910.00	(4,137,910.00)	1.09
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	300,000.00	(300,000.00)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,065,700.00	86,227,407.67	2,838,292.33	0.97
210201	Тэтгэврийн даатгал	60,564,700.00	58,723,331.91	1,841,368.09	0.97
210202	Тэтгэмжийн даатгал	7,125,300.00	6,878,393.92	246,906.08	0.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,562,600.00	3,439,197.00	123,403.00	0.97
210204	Ажилгүйдлийн даатгал	3,562,600.00	3,434,697.00	127,903.00	0.96
210205	Эрүүл мэндийн даатгал	14,250,500.00	13,751,787.84	498,712.16	0.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	569,223,500.00	485,437,455.12	83,786,044.88	0.85
210301	Гэрэл, цахилгаан	46,478,100.00	44,791,891.12	1,686,208.88	0.96
210302	Түлш, халаалт	512,865,400.00	430,202,564.00	82,662,836.00	0.84
210303	Цэвэр, бохир ус	9,880,000.00	10,443,000.00	(563,000.00)	1.06
2104	Хангамж, бараа материалын зардал	38,189,800.00	34,368,029.00	3,821,771.00	0.90
210401	Бичиг хэрэг	6,560,000.00	6,559,110.00	890.00	1.00
210402	Тээвэр, шатахуун	17,400,000.00	17,400,000.00	-	1.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,929,800.00	3,153,720.00	776,080.00	0.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,000,000.00	4,956,000.00	3,044,000.00	0.62
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,300,000.00	2,299,199.00	801.00	1.00
2105	Нормативт зардал	900,000.00	900,000.00	-	1.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	900,000.00	900,000.00	-	1.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	118,821,200.00	115,610,567.70	3,210,632.30	0.97
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,000,000.00	16,578,000.00	2,422,000.00	0.87
210602	Тавилга	15,000,000.00	15,030,000.00	(30,000.00)	1.00
210604	Урсгал засвар	84,821,200.00	84,002,567.70	818,632.30	0.99
2107	Томилолт, зочны зардал	11,200,000.00	9,752,000.00	1,448,000.00	0.87
210702	Дотоод албан томилолт	11,200,000.00	9,752,000.00	-	1.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,151,500.00	29,887,936.00	1,448,000.00	0.83
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	24,700,000.00	24,700,000.00	1,263,564.00	0.96

	үйлчилгээний төлбөр хураамж				
210803	Даатгалын үйлчилгээ	426,700.00	275,830.00	-	1.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,160,800.00	441,250.00	282,000.00	0.93
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	264,000.00	154,000.00	150,870.00	0.65
210807	Газрын төлбөр	600,000.00	598,856.00	1,144.00	1.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	0.00	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,781,300.00	65,259,042.00	9,522,258.00	0.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,281,300.00	55,768,342.00	9,512,958.00	0.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,500,000.00	9,490,700.00	9,300.00	1.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,323,400.00	21,323,344.16	55.84	1.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,323,400.00	21,323,344.16	55.84	1.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,623,400.00	19,623,344.16	55.84	1.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	1,700,000.00	-	1.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	984,793,600.00	730,588,295.00	254,205,305.00	0.74
223001	Бусад хөрөнгө	984,793,600.00	730,588,295.00	254,205,305.00	0.74
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	984,793,600.00	71,079,000.00	194,953,300.00	0.27
230001	Эргэж төлөгдөх зээл	984,793,600.00	71,079,000.00	194,953,300.00	0.27
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,918,009,200.00	2,512,691,668.00	405,317,532.00	0.86
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,358,848,000.00	2,361,315,250.00	(2,467,250.00)	1.00
320001	Орон нутгийн төсвөөс	1,633,895,900.00	1,664,636,250.00	(30,740,350.00)	1.02
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	724,952,100.00	696,679,000.00	28,273,100.00	0.96
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	559,161,200.00	151,376,418.00	407,784,782.00	0.27
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	232,479,500.00	151,376,418.00	81,103,082.00	0.65
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	326,681,700.00	0.00	326,681,700.00	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөг)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	278,883.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	278,883.39

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	278,716.84
2107	Томилолт, зочны зардал	15,200.00
210702	Дотоод албан томилолт	15,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	263,516.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	263,516.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	166,547.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	166,547.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	166,547,00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	278,883.39
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	278,883.39
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	278,883.39
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дашинчилэн сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Анхбаяр гүйцэтгэж, дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Энхцоодол хяналтыг хэрэгжүүлсэн.

Дашинчилэн сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 03/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 3,141.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 48.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 36.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 65 заалтаас шалгагдагч байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай 2 заалтын хэрэгжилтэд аудитын горим, сорил гүйцэтгэж ажиллалаа.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд 4 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хугацаанд бүрэн мэдээллэж ажиллах.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох нийцсэн/ гэж дүгнэлээ.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Өмнөх онд завсрын аудитаар бараа материалын тайлангийн 169.5 мянган төгрөгийн 6 дансанд, үндсэн хөрөнгийн тайлангийн 2,328.2 сая төгрөгийн 7 дансны үлдэгдэлд түүврийн тооллого хийж, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, коджуулалтыг тулган баталгаажуулалт хийсэн.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр зөвлөмжийн төлөвлөгөө болон биелэлтийг ирүүлсэн.

Хүснэгт 8. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	3	222.9	3	222.9	100
Нийт дүн	3	222.9	3	222.9	100

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн аудитаар сумын төсвийн орлогын зарим татварын орлого дутуу төлөвлөсөн хэмжээндээ хүрэхгүй байгааг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн байна.

Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 5 төсвийн захирагч, орон нутгийн төсвийн орлогын дансыг хамруулахаас 1 байгууллагад 1 дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг аудитын түүвэрт хамрууллаа. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэлийг хавсралт хүснэгтээр нэгтгэн гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар нийт 80.6 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 80.6 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус сангаас гамшгаас хамгаалах чиглэлээр зарцуулсан 40.5 сай төгрөгийн хөрөнгийг шууд зардлаар тайлагнасан, бараа материалын тайлан гаргаагүй

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 8 дугаар зүйл, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх зааврын 6.9, 6.10 дахь заалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: НБББББ-ын дагуу тайланг нярвын ажил үүргийн хуваарийн дагуу гүйцэтгүүлж, дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллах.

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын тайлан гаргаагүй, сангаас бэлтгэсэн 1.9 сая төгрөгийн материалыг шийдвэргүйгээр шууд зардлаар бүртгэж зарцуулсан.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 8 дугаар зүйл, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх зааврын 6.9, 6.10 дахь заалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: НБББББ-ын дагуу тайланг нярвын ажил үүргийн хуваарийн дагуу гүйцэтгүүлж, дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллах.

3. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал.

Илрүүлэлт: МТТАТ-ын 2023 оны үлдэгдлийг бүрэн төсөвт оруулаагүй, 213 айл өрхийн татвар төлөгдөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1"хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Малын тоо толгойн албан татварын тухай 4 дүгээр зүйлийн 4.1"Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээд нь албан татвар төлөгч байна",7 дугаар зүйлийн 7.1"Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө" гэсэн заалт болон эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн төсвийн орлогыг бодитой төлөвлөж, төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ	1	2.3			1	2.3	1	2.3				
ЗДТГ	1	23.3			1	23.3	1	23.3				
Дүн	2	25.6			2	25.6	2	25.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая

төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ИТХ	2	2.1					2	2.1				
ЗДТГ	4	8.8					4	8.8				
ХХСан	1	5.8	1	5.8								
ОНХСан	1	0					1	0				
БХСан	1	1.9					1	1.9				
ЖДҮДСан	1	40.4					1	40.4				
ТТЗ	1	38.3					1	38.3				
Дүн	11	97.3	1	5.8			10	91.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ	1	0					1	0
ОНХС	1	814.0					1	814.0
Дүн	2	814.0					1	814.0